



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/НН

Улаанбаатар хот

「Зээл, зээлийн хүүг балансаас балансад
шилжүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/198 дугаар “Зээл, зээлийн хүүг балансаас балансад шилжүүлэх тухай” захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн улсын Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулсан Мянганы сорилтын компакт гэрээ хүчин төгөлдөр болоход тавигдаж байгаа урьдчилсан болзолт нөхцөлийг хангах хүрээнд “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн тайланд бүртгэлтэй МОН 2937 МОН-3890 дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээний үндсэн болон хүүгийн төлбөр 209,327,497,469.68 /хоёр зуун есөн тэрбум гурван зуун хорин долоон сая дөрвөн зуун ерэн долоон мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг жаран найман мөнгө/ төгрөгийн урт хугацаат өглөгийг төсөл хэрэгжиж дуусах хүртэл Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын санхүүгийн тайланд шилжүүлэн, зохих журмын дагуу хасалт хийж, холбогдох бичиг баримтыг актаар хүлээлгэн өгөхийг “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /Ц.Төрхүү/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирж буй урт хугацаат өглөгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэн авч, холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, тайлагнан ажиллахыг Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэгт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Б.Болор-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА  М. БАЯРАА


1119282495 ☎ 2678689

115050000227